



**Хот, суурины ус хангамж, аритгах татуургын  
ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл**

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ  
ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ  
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
ЭЗЭМШИГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА,  
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАЙЛАНД  
ХИЙСЭН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН  
ТАЙЛАН**

**2015 он**

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ,  
ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТАЙЛАН

---

Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг  
зохицуулах зөвлөл

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ  
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА,  
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ  
НЭГДСЭН ТАЙЛАН**

## Гарчиг

Гарчиг.....	3
Товчилсон үгс .....	4
Нэг. Ерөнхий зүйл.....	5
Хоёр. Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд .....	6
2.1. Усны баланс, усны чанар.....	8
2.2. Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа .....	10
2.3. Хэрэглэгчийн судалгаа, усны тоолууржилт .....	12
2.4. Ус хангамж, ариутгах татуургын барилга, байгууламжийн өнөөгийн байдал .....	15
2.5. Ажиллах хүчин, дундаж цалин .....	16
Гурав. Санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд .....	17
3.1. Үйл ажиллагааны орлого .....	17
3.2. Үйл ажиллагааны зардал.....	20
3.3. Ашиг, алдагдал .....	23
3.4. Авлага, өр төлбөр .....	24
Дөрөв. Бусад үзүүлэлт .....	26
4.2. Цэвэр ус хангамжийн тасалдал.....	27
4.3. Хэрэглэгчийн санал гомдол, засвар үйлчилгээ үзүүлсэн судлагаа .....	27
Тав. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт.....	28
5.1. Орлогын 1 төгрөгт ногдох зардал.....	28
5.2. Борлуулсан 1 м <sup>3</sup> усанд ногдох үйл ажиллагааны зардал .....	29
5.3. Эргэлтийн харьцаа.....	29
5.4. Төлбөр гүйцэтгэх чадварын харьцаа .....	30
5.5. Үйл ажиллагааны ашгийн норм .....	30
ДҮГНЭЛТ .....	30
Хавсралт 1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдээс .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Хавсралт 2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санхүү- эдийн засгийн зарим үзүүлэлт, харьцааны шинжилгээ .....	<b>Error! Bookmark not defined.</b>

## **Товчилсон үгс**

ОБУ	Орлого болоогүй ус
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНТҮГ	Орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар
ОСАҮ	Орон сууцны ашиглалт, үйлчилгээ
ОСНААУГ	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар
ТЗЭ	Тусгай зөвшөөрөл эзэмшигч
ТЗ	Тусгай зөвшөөрөл
УСУГ	Ус сувгийн удирдах газар
УТБ	Ус түгээх байр
УХАТ	Ус хангамж, ариутгах татуурга
ХИХУГ	Хэсэгчилсэн инженерийн удирдах газар
ЭХУХ	Эрчим хүч, ус хангамж
ЭХЦ	Эрчим хүчний цех

## Нэг. Ерөнхий зүйл

Зохицуулах зөвлөл нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7-д заасны дагуу тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хянах, үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор 2015 оны жилийн эцсийн тайлан, мэдээ, тэдгээрийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдэд тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Тайлант жилийн эцэст нийт 145 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага (ТЗЭ) үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд байршлаар нь авч үзвэл:

- Орон нутагт УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний үйл ажиллагаа явуулж байгаа - 44
- Нийслэлийн төвийн 6 дүүрэгт УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний ОНӨААТҮГ – 3
- Нийслэлд УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний хувийн хэвшлийн компани - 61
- Бусад чиглэлээр 37 аж ахуйн нэгж тус тус үйл ажиллагаа явуулж байна.



**Зураг 1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байршил**

Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 30.3 хувь нь орон нутагт, 69.7 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотод барилгажилт эрчимтэй явагдаж, орон сууцны хорооллууд нэмэгдэж байгаатай холбоотойгоор салбарт хувийн хэвшлийн оролцоо өссөөр байгааг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал 2014 онд 45 хувийн компани УХАТ-ын тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан бол тайлант оны жилийн эцсийн дүнгээр 61 болж 16-аар нэмэгджээ.

2015 оны жилийн эцсийн хяналт үнэлгээний тайланд УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ эрхэлдэг 100 байгууллага хамрагдахаас төрийн өмчит 1, Улаанбаатар хотын харьяа ОНӨААТҮГ 5, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг 5, Монгол-Оросын хамтарсан ХХК 1, аймаг, орон нутгийн өмчит 29, хувийн хэвшлийн 57 тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 98 аж ахуйн нэгж зохих маягтын дагуу мэдээ тайлангаа ирүүлснийг нэгтгэн хяналт-үнэлгээ хийв. ТЗЭ-дийн хяналт-үнэлгээнд хамрагдах түвшин 98 хувьд хүрч, өмнөх оноос 8.9 пунктээр нэмэгдсэн байна. Ийнхүү тайлан, мэдээ ирүүлэх түвшин нэмэгдсэн боловч тайлан мэдээ шаардлага хангахгүй, зарим тоо мэдээ зөрүүтэй, дутуу зэргээс хугацаа алдах явдал гарсан болно. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны тайлан, мэдээг Хэнтий аймгийн “Бор-

Өндөр хот тохижилт” ОНТҮГ, Улаанбаатар хотын "Цонхлон үйлс" ХХК огт ирүүлээгүй байна.

Үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн хяналт-үнэлгээнд ТЗЭ аж ахуйн нэгжүүдийн санхүү, эдийн засгийн байдал, усны баланс, ажиллагсдын нийгмийн байдал, хэрэглэгчдийн тоолууржилт, ус хангамжийн тасалдал, дуудлагын үйлчилгээ, санал гомдол зэргийг хамруулан авч үзлээ.

## Хоёр. Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо 2014 онд 122 байсан бол 2015 онд 145 болж 23 байгууллагаар нэмэгдсэн байна. Ус хангамж, ариутгах татуургын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудыг тоо, ТЗ-ийн чиглэл, өмчийн хэлбэрээр дараах хүснэгтэд үзүүлэв (Хүснэгт 1).

**Хүснэгт 1. Ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагууд**

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төрөл	ТЗЭ-ийн тоо				өсөлт + бууралт -
		2012 он	2013 он	2014 он	2015 он	
1	<b>УБ хотын УСУГ болон аймаг, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллага</b>	<b>39</b>	<b>42</b>	<b>45</b>	<b>47</b>	<b>2</b>
	Үүнээс: Төрийн өмчит	1	1	1	1	0
	Нийслэл, орон нутгийн өмчит	28	28	30	31	1
	Хувийн хэвшлийн	6	6	6	7	1
	Бусад /хувь нийлүүлсэн/	4	7	8	8	0
2	<b>Орон сууцны ашиглалт, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүд</b>	<b>56</b>	<b>67</b>	<b>48</b>	<b>63</b>	<b>15</b>
	Үүнээс: Төрийн өмчит	1	1	1	1	0
	Нийслэлийн өмчит	23	24	3	3	0
	Хувийн хэвшлийн	31	40	43	59	16
	Бусад	1	2	1	0	-1
3	Бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ эрхэлдэг	-	5	18	24	6
4	УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ эрхэлдэг	-	1	1	1	-
5	Бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ эрхэлдэг	1	1	1	1	-
6	Цэвэр ус цэвэршүүлэн савлах үйлдвэр	2	7	9	9	-
<b>Нийт</b>		<b>98</b>	<b>123</b>	<b>122</b>	<b>145</b>	<b>23</b>

2015 онд Дорноговь аймагт нэг, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд нэг аж ахуйн нэгж ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар үйлчилгээ, Улаанбаатар хотод хувийн хэвшлийн 16 компани орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, 6 газар бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан байна.

## Хүснэгт 2. ТЗЭ байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2012 он	2013 он	2014 он	2015 он	өсөлт + бууралт -
1	<b>Тусгай зөвшөөрөл эзэмшигчид</b>						
	ТЗЭ-ийн тоо	тоо	98	123	122	145	23
	Үүнээс: Хяналт үнэлгээнд хамрагдах	тоо	97	116	92	100	8
	Хяналт үнэлгээнд хамрагдсан	тоо	71	80	82	98	16
	Хяналт үнэлгээнд хамрагдсан хувь	%	73.2%	69.0%	89.1%	98.0%	8.9
2	<b>Усны баланс</b>						
	Олборлосон усны хэмжээ	мян.м <sup>3</sup>	90,636.9	92,818.4	100,987.7	101,625.8	638.1
	Худалдан авсан усны хэмжээ	мян.м <sup>3</sup>		30,046.3	33,374.5	34,258.4	883.9
	Борлуулсан усны хэмжээ	мян.м <sup>3</sup>	72,484.3	76,514.5	114,347.6	116,159.5	1,811.9
	Өөрийн хэрэглээний усны хэмжээ	мян.м <sup>3</sup>	0.0	0.0	1,724.9	649.2	-1,075.7
	Орлого болоогүй усны хэмжээ	мян.м <sup>3</sup>	18,152.6	16,303.9	18,289.7	19,075.6	785.9
	Орлого болоогүй усны эзлэх хувь	%	20.0%	17.6%	18.1%	18.8%	0.7
	Татан зайлуулсан бохир усны хэмжээ	мян.м <sup>3</sup>	60,622.9	83,685.9	84,495.5	87,756.2	3,260.7
3	<b>Хэрэглэгчийн судалгаа</b>						
	Хэрэглэгчийн тоо	тоо	161,880	179,295	455,454	500,630	45,176.0
	Үүнээс: Аж ахуйн нэгж байгууллага	тоо	11,963	12,517	18,143	19,649	1,506.0
	Айл өрх - орон сууцны	тоо	149,917	166,778	195,268	229,057	33,789.0
	Ус түгээх байрнаас хэрэглэдэг	тоо			242,043	251,924	9,881.0
4	<b>Хэрэглэгчийн тоолууржилт</b>						
	Нийт дүнгээр	%	63.0%	67.4%	74.5%	79.8%	5.3
	Үүнээс: Аж ахуйн нэгж байгууллага	%	88.7%	94.1%	95.1%	96.9%	1.8
	Айл өрх - орон сууцны	%	56.0%	58.3%	72.6%	78.4%	5.8
5	<b>Ажиллах хүчин</b>						
	Нийт ажиллагсдын тоо	хүн	4,818	5,613	5,643	7,134	1,491.0
	Дундаж цалин	төг.	508,130	526,200	606,824	663,903	57,079.4
6	<b>УХАТ-ын үйл ажиллагааны санхүү, эдийн засгийн зарим үзүүлэлт</b>						
	Нийт орлого	сая.төг	70,702.1	79,675.7	99,421.6	125,395.1	25,973.5
	Нийт зардал	сая.төг	81,221.0	96,777.6	116,220.6	135,547.3	19,326.7
	Ашиг, алдагдал	сая.төг	-10,518.9	-17,101.9	-16,799.0	-10,152.2	6,646.8
	Орлогын 1 төгрөгт ногдох зардал	-	1.15	1.21	1.17	1.08	-0.1
	Ашгийн норм	0 дээш	-0.15	-0.21	-0.17	-0.08	0.1
	1 м <sup>3</sup> усанд ногдох зардал: Цэвэр ус	төг/м <sup>3</sup>			717.6	827.0	109.4
	Бохир ус	төг/м <sup>3</sup>			369.4	458.7	89.3
7	<b>Санхүүгийн тайлангийн зарим үзүүлэлт</b>						
	Эргэлтийн хөрөнгө	сая.төг			60,388.9	72,457.0	12,068.1
	Үндсэн хөрөнгө	сая.төг			314,370.0	495,207.4	180,837.4
	Дансны авлага	сая.төг			26,775.5	31,165.4	4,389.9
	Өр төлбөр	сая.төг	125,590.2	192,654.7	214,906.1	235,864.7	20,958.6
	Үүнээс: Богино хугацаат төлбөр	сая.төг		30,974.1	38,536.5	47,229.4	8,693.0
	Урт хугацаат төлбөр	сая.төг		161,680.6	176,369.7	188,635.3	12,265.7
8	<b>Санхүүгийн харьцаа</b>						
	Эргэлтийн харьцаа	1-с дээш			0.54	0.31	-0.24
	Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	2-с дээш			0.27	0.22	-0.05
	Авлагын эргэц	хоног			41.4	39.5	3.9
	Ашгийн норм	0 дээш			-0.169	-0.089	0.08

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний ТЗЭ байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг нэгтгэн дээрх Хүснэгт 2-т үзүүлэв.


Усны олборлолт, борлуулалт нэмэгдсэн бөгөөд орлого болоогүй усны эзлэх хувь улсын дунджаар 18.8 хувь болон өнгөрсөн оноос 0.7 пунктээр нэмэгдсэн нь хэрэглэгчийн тоолууржилт нэмэгдсэнээс голчлон шалтгаалжээ.

Тайлант оны дүнгээр хэрэглэгчийн тоо өмнөх онтой харьцуулахад 45.2 мянгаар өссөн бөгөөд үүний дотор зөөврийн болон УТБ-ны хэрэглэгч 9.9 мянга, төвлөрсөн шугамд холбогдсон айл өрх 33.8 мянга, ААНБ 1.5 мянгаар нэмэгдсэн байна. Энэ ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөсөн, мөн хяналт үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо өссөн зэрэгтэй холбоотой юм.

2015 онд ихэнх аймгуудад цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг шинэчлэсэн, зардалд хяналт тавин ажиллаж байгаагийн үр дүнд салбарын дүнгээр орлого нэмэгдэн, алдагдал буурч байгаа боловч санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд доогуур хэвээр байна.

## 2.1. Усны баланс, усны чанар

**Усны баланс:** Хяналт үнэлгээнд хамрагдсан ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхэлж байгаа 98 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 36 нь ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж хариуцан ажиллаж байна. 2015 оны жилийн эцсийн дүнгээр нийт 101.6 сая.м<sup>3</sup> ус олборлон боловсруулсан байна.



**Зураг 2. Усны баланс, мян.м<sup>3</sup>**

Мөн онд тусгай зөвшөөрөл эзэмшигчид 2015 онд давхардсан тоогоор нийт 116.2 сая.м<sup>3</sup> ус борлуулж, 0.65 сая.м<sup>3</sup> усыг өөрийн хэрэглээнд ашигласан бөгөөд усны алдагдал буюу орлого болоогүй усны хэмжээ 19.08 сая.м<sup>3</sup> болсон байна (Зураг 2). Орлого болоогүй ус өмнөх оноос 0.78 сая.м<sup>3</sup> –ээр өсчээ. Одоогийн байдлаар хэрэглэгчдийг бүрэн тоолууржуулаагүй тул зөвхөн орлого болоогүй усны хэмжээг тооцож гаргах боломжтой байна.


Тайлант онд Улаанбаатар хотын “УСУГ” 52,346.3 мян.м<sup>3</sup>, Эрдэнэт үйлдвэрийн “Эрчим хүчний цех” 17,872.7 мян.м<sup>3</sup>, “Энержи интернэшнл” ХХК 14,730.6 мян.м<sup>3</sup> ус тус тус олборлосон нь нийт усны олборлолтын 83.6 хувийг эзэлж байна.



**Ундны усны чанар:** Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ундны усны стандарт MNS 900:2005-ийг хангаж буй эсэхийг ус олборлон боловсруулж, дамжуулах үйл ажиллагаа эрхэлж буй “УСУГ” ОНӨААТҮГ болон хөдөө орон нутгийн 34 байгууллагын усны шинжилгээний үзүүлэлтээр харьцуулж дүгнэв.

Шинжилгээний дүнгээс үзэхэд Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын ундны усанд магнийн агууламж стандарт утгаас хэтэрсэн, Булган аймаг “Булган мээж”, Орхон аймаг “Эрдэнэт үйлдвэр” ХХК, Дархан-Уул аймаг “Дулаан шарын гол” ТӨХК, “Дархан ус суваг” ХК, “Эмтнаран” ОНӨААТҮГ зэрэг байгууллагуудын ундны усанд амт, үнэрийн агууламж стандарт утгаас их буюу тэнцүү гарсан байна.

Мөн Говьсүмбэр аймгийн “Ус-Ду” ОНӨҮГ, Завханы “Амь-Ус трейд” ХХК зэрэг байгууллагуудын ундны усны чанарт хийсэн шинжилгээний дүнгээр нянгийн тоо стандарт утгаас их гарсан тохиолдол илэрсэн. Энэ нь дээрх байгууллагууд усны эх үүсвэрийн ариутгал, халдваргүйжилтэнд анхаарах шаардлагатайг харуулж байна (Зураг 23). Түүнчлэн усны эх үүсвэрийн хамгаалалтын дэглэм, ариун цэврийн бүсийн хэрэгжилт орон нутагт хангалтгүй байгаа нь ч дээрх аймгуудын усны чанарт нөлөөлсөн гэж үзэхээр байна.



**Зураг 3. Ундны усны чанарын үзүүлэлт**

Аймаг, орон нутгийн ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүс зөрчигдсөнөөс энэхүү хамгаалалтын бүсэд хамрагдах газрыг дурын хүн өмчлөх, бохирын цооног байгуулах, хамгаалалтын бүсэд хүн ам олноороо суурьших, мал амьтны ялгадсаар ус, хөрсийг бохирдуулах, улмаар хүн амын дунд ундны уснаас шалтгаалах төрөл бүрийн халдварт өвчин үүсэх нөхцөлийг бүрдүүлээд байгаа нь тайлан мэдээний ундны усны чанарын үзүүлэлтээс тодорхой харагдаж байна.

Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн дэглэмийг Монгол Улсын Усны тухай хуулийн 31.3, 31.4-т заасны дагуу тогтоон хэрэгжилтэнд тухайн орон нутгийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавьдаг. Гэвч Зохицуулах зөвлөлөөс 2015 онд аймаг, орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан, нөхцөл шаардлага хангаж буй эсэхэд дүгнэлт гаргахад энэхүү хуулийн заалтын хэрэгжилт орон нутагт тун хангалтгүй байв. Цаашид энэхүү хуулийн заалтын хэрэгжилтийг хангахад орон нутгийн засаг, захиргааны байгууллагын оролцоо чухал юм.

## 2.2. Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа


Татан зайлуулсан бохир усны хэмжээ жилээс жилд өсч байгаа нь орон сууц шинээр ашиглалтад орж, хэрэглэгчийн тоо нэмэгдэж байгаатай салшгүй холбоотой. Тухайлбал, ТЗЭ аж ахуйн нэгжүүд 2015 онд нийт 87,756.2 мян.м<sup>3</sup> бохир ус татан зайлуулсан нь өмнөх оны мөн үеээс 3,260.7 мян.м<sup>3</sup> –ээр илүү байна.

Монгол улсын хэмжээнд 125 бохир ус цэвэрлэх байгууламж байгаагаас үйл ажиллагаа нь хэвийн 51, хагас ажиллагаатай 27, үлдсэн нь ажиллагаагүй байна. Нийт ТЗЭ байгууллагуудын цэвэрлэх байгууламжийн 63 хувийг биологийн, 37 хувийг механик цэвэрлэгээ бүхий цэвэрлэх байгууламж эзэлдэг.


Зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хариуцан ажиллуулж буй бохир ус цэвэрлэх байгууламжуудаас цэвэрлэгдэн гарч буй хаягдал усыг стандартын шаардлагад нийцүүлэн хаяж буй эсэхэд хяналт тавих зорилгоор шинжилгээний дүнг авах ажлыг тогтмолжуулж байна.

Хаягдал усны шинжилгээний дүнгээс үзэхэд байгаль орчинд сөрөг нөлөөгүй, холбогдох стандартын шаардлага ханган ажиллаж буй цэвэрлэх байгууламж цөөн, бохир ус цэвэрлэгээний түвшин доогуур байна. Ялангуяа бохир усанд зөвхөн механик цэвэрлэгээ хийгээд карт (хөрс) руу хаяж байгаа нь хөрс, агаарын бохирдол нэмэгдэхэд шууд нөлөө үзүүлж байна.


Зарим ТЗЭ-дийн Бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшинг БХХ, ХХХ, умбуур бодис зэрэг бохирдуулагч бодисын үзүүлэлтийг "Усны чанар. Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага" MNS 4943:2015 стандартын шаардлагатай харьцуулан дор үзүүлэв.



Зураг 4. Цэвэрлэх байгууламжаас хүрээлэн буй орчинд нийлүүлж буй хаягдал усандах умбуур бодис



Зураг 5. Цэвэрлэх байгууламжаас хүрээлэн буй орчинд нийлүүлж буй хаягдал усан дах БХХ



Зураг 6. Цэвэрлэх байгууламжаас хүрээлэн буй орчинд нийлүүлж буй хаягдал усан дах ХХХ

Хаягдал усан дах умбуур бодисын хэмжээ Улаанбаатар хот, Баян-Өлгий, Дундговь, Орхон, Хэнтий, Сэлэнгэ аймгийн Сайхан сумдын цэвэрлэх байгууламжийн хаягдал усанд стандартаас давсан бол Улаанбаатар, Налайх, Хэнтий, Сэлэнгэ аймгийн Сайхан суманд БХХ-ийн хэмжээ стандартаас давсан, Дундговь, Орхон, Хэнтий аймаг, Улаанбаатар хотод ХХХ-ийн агууламж стандартаас давсан үзүүлэлттэй байв.

Улаанбаатар хотын УСУГ-ын хариуцаж буй Төв цэвэрлэх байгууламж сүүлийн жилүүдэд хүчин чадлаас нь хэтэрсэн, бохирдол өндөртэй ус хүлээн авдгаас цэвэрлэгээний түвшин буурсан байна. Ийнхүү хүрээлэн буй орчинд нийлүүлж буй хаягдал бохир ус нь стандартын дээд хязгаараас давснаар байгаль орчин төдийгүй хүн амын эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах тул цэвэрлэгээний түвшинг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Энэ бүхнээс үзэхэд Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд хэрэглээнээс гарсан бохир усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэх, лагийг бүрэн боловсруулж, хөрсний


бохирдлыг бууруулахад онцгой анхаарч, цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэн сайжруулах, шинэ технологийг нэвтрүүлэх шаардлага тулгараад байна. Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдэн гарсан хаягдал бохир усны цэвэрлэгээний чанарын түвшин шаардлага хангахгүй байгаа үндсэн шалтгаан нь цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, их засвар хийх, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх хөрөнгө мөнгө дутагдалтай байдгаас голлон шалтгаалдаг байна.

### 2.3. Хэрэглэгчийн судалгаа, усны тоолууржилт

*Хэрэглэгчийн судалгаа:* 2015 оны жилийн эцсийн дүнгээр ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд нийт 500.63 мянган хэрэглэгчид үйлчилгээ үзүүлж байгаагаас 19.65 мянган хэрэглэгч буюу 3.9 хувь нь үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага, 229.06 мянга буюу 45.8 хувь нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон айл өрх, 251.92 мянган хэрэглэгч буюу 50.3 хувь нь зөөврийн усан хангамжтай байв.

**Хүснэгт 3. Хэрэглэгчийн судалгаа, 2015 оноор**

Хэрэглэгчийн тоо	тоо	%
<b>Нийт хэрэглэгч</b>	<b>500,630</b>	100%
Үүнээс: Зөөвөр, УТБ -аас	251,924	50.3%
Төвлөрсөн шугамнаас	248,706	49.7%
Үүнээс : Айл өрх	229,057	92.1%
ААНБайгууллага	19,649	7.9%



**Зураг 7. Хэрэглэгчийн судалгаа**


Тайлант онд төвлөрсөн шугамд холбогдсон хэрэглэгчийн тоолууржилтын түвшин улсын дунджаар 79.8 хувьд хүрсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 5.3 пунктээр өсчээ (Хүснэгт 4).

2015 онд хөдөө, орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын хэрэглэгчийн тоолууржилт дунджаар 79.3 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 6.9 пунктээр өссөн байна. Энэ нь шинээр ашиглалтад орж буй орон сууц 100 хувь тоолууртай

байгаагийн зэрэгцээ зарим аймгуудад тоолууржилт эрчимтэй явагдсаны үр дүн юм (Зураг 8).

**Хүснэгт 4. Хэрэглэгчийн тоолууржилт, 2015 оноор**


<b>Тоолууржилт</b>	<b>тоо</b>	<b>%</b>
<b>Төвлөрсөн шугамд холбогдсон хэрэглэгч</b>	248,706	
Үүнээс : Тоолууртай	198,553	<b>79.8%</b>
Тоолуургүй	50,153	20.2%
<b>Айл өрх</b>	229,057	
Үүнээс : Тоолууртай	179,506	<b>78.4%</b>
Тоолуургүй	49,551	21.6%
<b>ААНБайгууллага</b>	19,649	
Үүнээс : Тоолууртай	19,047	<b>96.9%</b>
Тоолуургүй	602	3.1%
<b>НИЙТ ТООЛУУРЖИЛТЫН ТҮВШИН</b>		<b>79.8%</b>




**Зураг 8. Хэрэглэгчийн тоолууржилт байршлаар, 2015 он**

Орон нутагт айл өрхийн тоолууржилт дунджаар 78 хувь байгаа бөгөөд хамгийн доогуур түвшинтэй нь Сэлэнгэ аймгийн “Гавшгай ус” ХХК, “Урсгал ус” ОНӨААТҮГ, Завханы “Амь-Ус трейд” ХХК, Говь-Алтайн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ, Ховд аймгийн “Шим-Ус” ХХК зэрэг байгууллагууд байв. Үүнээс: Сэлэнгэ аймгийн Сайхан суманд (“Гавшгай ус” ХХК) хөрөнгө, мөнгөний асуудлаас шалтгаалан тоолууржуулах ажил огт эхлээгүй байна.

Булган аймгийн “Булган мээж” ХХК, Орхон аймаг “Эрдэнэт УДТС” ОНӨ ХК, Дорноговь аймгийн “Чандмань илч” ХХК, Өвөрхангай аймгийн “Онги ус” ОНӨААТҮГ, “Хархорин ус суваг” ХХК-иуд айл өрхийг тоолууржилтад бүрэн хамруулж чадсан байна (Зураг 9). Улаанбаатар хотын “ОСНААУГ” ОНӨААТҮГ-т айл өрхийн тоолууржилтын түвшин бага буюу 64.1 хувь байгаа нь орон нутаг болон хувийн хэвшлийн байгууллагуудын дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Иймд айл өрхийг тоолууржуулах ажлыг эрчимтэй явуулах талаар онцгой анхаарах шаардлагатай байна.



**Зураг 9. Айл өрхийн тоолууржилт, 2015 он**



**Зураг 10. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тоолууржилт, 2015 он**

2015 оны тайлан мэдээгээр үйлдвэр, аж ахуйн нэгжийн тоолууржилт хөдөө, орон нутагт дунджаар 91.8 хувьтай байгаа нь өнгөрсөн оныхоос 4.2 пунктээр өссөн үзүүлэлт юм. Тоолууржилтын түвшин доогуур аймагт Сэлэнгэ "Гавшгай ус" ХХК, Ховд "Шим ус" ХХК, Завхан "Амь ус трейд" ХХК орж байна.

Зохицуулах зөвлөлөөс хэрэглэгчийн тоолууржилтын түвшин доогуур үзүүлэлттэй байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудтай энэ үзүүлэлтийг нэмэгдүүлэх шаардлага тавьж, гүйцэтгэлийн гэрээ байгуулан ажиллаж байна.

## 2.4. Ус хангамж, ариутгах татуургын барилга, байгууламжийн өнөөгийн байдал


Тайлант оны дүнгээр ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшиж буй байгууллагууд улсын хэмжээнд ф5-ф900мм-ийн диаметр бүхий нийт 2.350 мянган км орчим урт цэвэр ус хангамжийн шугам сүлжээ хариуцан ажиллаж байна.

Эдгээрээс 1970-2000 оны хооронд ашиглалтад орсон буюу 30 хүртэлх жилийн насжилттай шугам хоолой нийт цэвэр усны шугам сүлжээний 85 хувийг эзэлдэг. Шугам хоолойн насжилт өндөр байх нь түүгээр дамжуулагдах цэвэр усны чанарт нөлөөлөх, усны алдагдал үүсгэх, засвар үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг нөлөөтэй тул цаашид шугам хоолойн шинэчлэлтийн ажилд үе шаттайгаар хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.

2015 оны жилийн эцсийн байдлаар тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд ф50-ф1400мм-ийн диаметр бүхий 1.18 мянга шахам км урттай бохир усны шугам сүлжээ хариуцаж байгаагийн 50 хувь нь ширмэн хоолой, 5-6 хувь нь вааран, 40-45 хувь нь хуванцар шугам хоолой байна.

Бохирын нийт шугам хоолойн 80 орчим хувийг 30-40 жилийн насжилттай шугам хоолой эзэлж байгаагаас Улаанбаатар хотын хувийн хэвшлийн орон сууц ашиглалтын байгууллагуудын хариуцаж буй ариутгах татуургын шугам хоолой харьцангуй шинэвтэр, харин ОНӨААТҮГ-уудын шугам хоолойн 80 гаруй хувь нь насжилт өндөр байна.

Нийслэлийн ТЗЭ байгууллагууд цэвэр, бохир усны нийт 1.1 мянган км шугам сүлжээний ашиглалт үйлчилгээг хариуцан ажиллаж байгаагаас 66.4 хувийг нь ОНӨААТҮГ-ууд хариуцан ажиллаж байна (Зураг 11).



**Зураг 11. Улаанбаатар хотын шугам сүлжээний өмчлөл, ашиглалт, 2015 он**

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 19.1-д заасны дагуу ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ улс болон орон нутгийн өмчинд байх ёстой боловч Улаанбаатар хотын захиргаанаас шугам сүлжээг өмчлөх асуудлыг удаашруулж байгаагаас хувийн хэвшлийн байгууллагуудын өмчлөлд байгаа цэвэр, бохир

усны шугам сүлжээний эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеээс 6.6 пунктээр өсч 33.6 хувьд хүрчээ.

Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, тэднийг чанартай үйлчилгээгээр хангахын тулд ТЗЭ-д өөрийн хариуцаж буй инженерийн барилга, байгууламж, шугам сүлжээний элэгдлийн санг бодитойгоор байгуулах, төлөвлөгөөт засвар, үйлчилгээг чанаржуулах зайлшгүй шаардлагатай юм.


## 2.5. Ажиллах хүчин, дундаж цалин

2015 оны тайлан мэдээнээс үзэхэд Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний ТЗЭ байгууллагууд нийт 7.1 гаруй ажиллагсадтайгаас 4.8 хувь нь удирдлага, 20.3 хувь нь инженер техникийн ажилчид, 74.8 хувь нь мэргэжилтэй ажилчид байв.

### Хүснэгт 5. Ажиллагсдын судалгаа

Ангилал	Удирдлага	ИТА	Мэргэжлийн ажилчин	Бүгд
Аймаг, орон нутгийн ТЗЭ байгууллага	145	503	2,461	<b>3,109</b>
УБ хотын ОНӨААТҮГ-ууд	63	654	2,375	<b>3,092</b>
Хувийн хэвшлийн ТЗЭ	138	294	501	<b>933</b>
<b>УХАТ-н салбарын нийт ажиллагсад</b>	<b>346</b>	<b>1,451</b>	<b>5,337</b>	<b>7,134</b>

Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын мэргэжлийн хүний нөөцийн бүрдэлт улсын дунджаар 80.5 хувь, аймаг, орон нутгийн дундаж 86 хувь, УБ хотод дунджаар 75 хувьтай байна (Зураг 12)



Зураг 12. Хүний нөөцийн судалгаа

2015 оны эцсийн байдлаар нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүний нөөцийн бүрдүүлэлт дунджаар 80 хувь байгаа нь 2013 оныхтой харьцуулахад 40 хувиар, 2014 оныхтой харьцуулахад 22.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй (Зураг 13) байна.

Хүний нөөцийн бүрдэлт хамгийн бага нь Булган аймгийн “Булган мээж” ХХК, Завхан аймгийн “Амь ус трейд” ХХК, Өмнөговь аймгийн “Гүний-Ус” ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагууд салбарын дундаж үзүүлэлтээс даруй 2 дахин бага буюу 36-45.5 хувьтай байна. Улаанбаатар хотын хэмжээнд хүний нөөцийн бүрдэлт хамгийн бага нь 27.6 хувьтай орон сууц ашиглалтын “Ган инженеринг” ХХК, 33.3 хувьтай “Таван өндөр” ХХК зэргийг



дурдаж болно. Эдгээр байгууллагууд цаашид боловсон хүчний бүрдэлтийг сайжруулахад анхаарал тавьж ажиллах шаардлагатай юм.

Хүний нөөцийн бүрдэлт хамгийн өндөр буюу 100 хувь хүрсэн байгууллагуудад “УСУГ” ОНӨААТҮГ, “Хаусинг холд” ХХК, “Эс жи ливинг” ХХК хөдөө орон нутагт 100%-тай болон “Чандмань Баянхонгор” ХК, “Ус Ду” ОНӨААТҮГ, “Хархорин ус суваг” ХХК, “Энержи Интернэшнл” ХХК, “Ухаа худаг ус хангамж” ХХК, “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Шим ус” ХХК орж байна.

Салбарт ажиллагсдын дундаж цалин 663.9 мянган төгрөг болсон нь өмнөх оны мөн үеийнхээс 11.2 хувиар нэмэгджээ. Гэсэн хэдий ч салбарын дундаж цалин улсын дунджаас доогуур хэвээр буюу нь 2015 оны улсын дундаж (851.4 мян.төгрөг)-аас 22 хувиар бага байна.

2015 онд ТЗ эзэмшигч байгууллагууд өөрсдийн ажиллагсдын нийгмийн асуудалд нийт зардлын 0.9 хувийг буюу 1.2 тэрбум төгрөг зарцуулсан гэсэн мэдээ ирүүлсэн байна.

Цаашид салбарын боловсон хүчний асуудлыг онцгой анхааран цалин хөлсийг нэмэгдүүлж, нийгэм хангамжийг дээшлүүлэх нь чадварлаг мэргэжилтнүүдийг татах, салбарыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Зохицуулах зөвлөлөөс ТЗЭ байгууллагуудад тайлан мэдээний тоон үзүүлэлтийг үнэн бодитоор гаргахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

## Гурав. Санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд


### 3.1.Үйл ажиллагааны орлого

2015 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд нийт 248.3 тэрбум төгрөгний борлуулалтын орлоготой ажилласан нь өмнөх оноос 7.7 хувиар буюу 17.85 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нийт орлогын 28.4 хувийг аймаг, орон нутгийн аж ахуйн нэгжийн орлого, 45.6 хувийг Улаанбаатар хотын УСУГ ОНӨААТҮГ-ууд, 16.1 хувийг хувийн хэвшлийн байгууллагын орлого, 9.8 хувийг уул уурхайн ус хангамж, ариутгах татуургын байгууллагуудын борлуулалт бүрдүүлжээ

**Хүснэгт 6. ТЗЭ байгууллагуудын үйл ажиллагааны орлого, сая төг.**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2012 он	2013 он	2014 он	2015 он	Өсөлт /+/ Бууралт /-/
Ус сувгийн удирдах газар	25,112.4	26,838.7	37,182.2	45,136.5	7,954.3
УБ хотын ОНӨААТҮГ-ууд	37,889.0	45,854.0	53,472.5	68,157.2	14,684.7
Хувийн хэвшлийн компаниуд	771.8	12,753.7	43,301.2	40,092.7	-3,208.5
Аймаг, орон нутгийн байгууллагууд	37,533.8	53,989.2	66,177.6	70,604.5	4,426.9
Уул уурхайн харьяа тусгай зөвшөөрөл эзэмшигчид*	14,369.3	25,681.5	30,329.4	24,322.5	-6,006.9
<b>Нийт дүн</b>	<b>115,676.3</b>	<b>165,117.0</b>	<b>230,462.9</b>	<b>248,313.4</b>	<b>17,850.5</b>

Тайлбар: \* Томоохон уул уурхай, түүний орчмын хот, суурин газрын хэрэглэгчдэд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлдэг Эрдэнэт УБҮ-ийн “Эрчим хүчний цех” болон “Энержи ресурс”, “Хаанзаа” ХХК зэрэг ТЗЭ-д орно.



Түүнчлэн тусгай зөвшөөрөл эзэмшигчид орлогынхоо 50.5 хувийг ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээнээс, 38.8 хувийг дулаанаас, 10.7 хувийг бусад үйл ажиллагаанаасаа төвлөрүүлсэн байна. Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээий орлого өнгөрсөн оны үзүүлэлтээс 7.4 пунктээр өсчээ.

**Зураг 13. ТЗЭ-дийн орлогын бүтэц**

Орлогын өсөлтийн дийлэнхийг Улаанбаатар хотын байгууллагууд эзэлж байгаад 2015 онд цэвэр, бохир усны үйлчилгээ болон дулааны тариф нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээнээсээ 125.9 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь орлого өмнөх оноос 26 тэрбум төгрөгөөр буюу 26.1 хувиар өсчээ (Хүснэгт 7). Ийнхүү орлого өссөн нь аймаг, орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг 2015 оны 1-р сараас шат дараатай нэмэгдүүлж, суурь хураамж мөрдүүлж эхэлсэн болон 2015 оны 9 дүгээр сараас Улаанбаатар хотын цэвэр бохир усны үйлчилгээний тариф нэмэгдсэн, түүнчлэн хэрэглэгчийн тоо өссөнтэй холбоотой.

**Хүснэгт 7. Тусгай зөвшөөрлийн хүрээнд борлуулалтын орлого, сая төг.**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2012 он	2013 он	2014 он	2015 он	Өсөлт +/- Бууралт -/-
Ус сувгийн удирдах газар	25,112.4	26,838.7	36,663.7	45,136.5	8,472.8
УБ хотын ОНӨААТҮГ-ууд	10,475.4	13,825.1	16,574.9	21,592.1	5,017.2
Хувийн хэвшлийн компаниуд	771.8	2,090.1	3,703.8	7,735.4	4,031.6
Аймаг, орон нутгийн байгууллагууд	19,992.8	21,812.5	23,792.5	31,277.4	7,484.9
Уул уурхайн харьяа тусгай зөвшөөрөл эзэмшигчид*	14,029.2	24,849.7	18,686.7	19,653.7	967.0
<b>Нийт дүн</b>	<b>70,381.6</b>	<b>89,416.0</b>	<b>99,421.6</b>	<b>125,395.1</b>	<b>25,973.5</b>

Тайлант онд “УСУГ” ОНӨААТҮГ-ын ажил үйлчилгээ, борлуулалтын орлого 45.14 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 8.47 тэрбум төгрөгөөр буюу 23.1 хувиар нэмэгджээ. Нийт орлогын 58.4 хувь буюу 26.35 тэрбум төгрөгийг цэвэр усны борлуулалт, 36.1 хувь буюу 16.28 тэрбум төгрөгийг бохир ус татан зайлуулах үйлчилгээний орлого, үлдэх 2.6 хувь буюу 1.19 тэрбум төгрөгийг суурь хураамжийн орлого, 2.9 хувь буюу 1.32 тэрбум төгрөгийг бусад ажил үйлчилгээний борлуулалт бүрдүүлжээ. УТБ, зөөврийн ус хангамжийн үйлчилгээний орлого 2.7 хувь буюу 1.22 тэрбум төгрөг болсон байна.

Улаанбаатар хотын, тусгай зөвшөөрөл эзэмшигч бусад ОНӨААТҮГ-ууд 2015 онд тусгай зөвшөөрлийн хүрээнд 21.59 тэрбум төгрөгийн орлоготой ажилласнаар борлуулалт өмнөх оноос 5.02 тэрбум төгрөг буюу 30.3 хувиар өссөн байна. Суурь хураамжийн орлого 3.23 тэрбум төгрөг буюу ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний орлогын 14.9 хувийг бүрдүүлжээ. Ийнхүү орлого өсөхөд тарифын өөрчлөлт, шинэ бүтээн байгуулалттай

холбоотойгоор орон сууц ашиглалтад орон хэрэглэгчийн тоо нэмэгдэж байгаа нь голчлон нөлөөлжээ.

Улаанбаатар хотын хувийн хэвшлийн компаниуд нь ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээнээсээ 2015 онд 7.74 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан дүн гарсан нь 2014 оноос 4.03 тэрбум төгрөгөөр буюу 2 дахин нэмэгдсэн бөгөөд энэ нь юуны өмнө хувийн хэвшлийн байгууллагын мэдээ, тайлан ирүүлэх түвшин сайжирсантай холбоотойн дээр орон сууцны тоо хурдацтай өсч байгаа, суурь хураамж нэвтрүүлсэн нь зохих хэмжээгээр нөлөөлсөн байна. Суурь хураамжийн орлого нийт борлуулалтын орлогын 23.8 хувийг бүрдүүлжээ.

Аймаг, орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд 2015 онд тусгай зөвшөөрлийн хүрээнд 31.28 тэрбум төгрөгийн орлоготой ажилласнаар өмнөх оны мөн үеийнхээс орлого 7.48 тэрбум төгрөг буюу 31.5 хувиар нэмэгдсэн байна. Орлогын 52.2 хувийг цэвэр усны, 35.4 хувийг бохир усны, 6.2 хувийг суурь хураамжийн, 6.2 хувийг бусад орлого эзэлж байна.

Уул уурхайн ус хангамжийн үйлчилгээ үзүүлдэг "Энержи интернэшнл" ХХК, "Ухаа худаг ус хангамж" ХХК-иудын орлого өмнөх оноос 7.3 тэрбум төгрөгөөр буурсан нь тухайн жилд энэ салбарын үйлдвэрлэл буурсантай холбоотой. Уул уурхайн харьяа ТЗЭ-дийн орлогын дийлэнх буюу 92.4 хувийг "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ий Эрчим хүчний цехийн орлого эзэлж байна.


Салбарын хэмжээнд ус хангамж ариутгах татуургын үйлчилгээний орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 59.2 хувийг цэвэр усны орлого, 31.2 хувийг бохир усны үйлчилгээний орлого, 6.6 хувийг суурь хураамжийн орлого, 3.1 хувийг тусгай зөвшөөрлийн хүрээнд бусад орлого тус тус эзэлж байна (Хүснэгт 8, Зураг 14).

Түүнчлэн нийт орлогын дийлэнх буюу 52.2 хувийг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлсэн үйлчилгээнээс олжээ (Хүснэгт 9, Зураг 15).

**Хүснэгт 8. УХАТ-ын үйлчилгээний орлого, үйлчилгээний төрлөөр**

Орлогын ангилал	Хэмжээ, сая.төг
<b>Нийт орлого</b>	<b>125,395.1</b>
Цэвэр усны орлого	74,201.1
Бохир усны орлого	39,065.1
Суурь хураамжийн орлого	8,222.8
ТЗ-ийн хүрээнд бусад орлого	3,906.0

**Зураг 14. Орлогын бүтэц, үйлчилгээний төрлөөр**



**Хүснэгт 9. УХАТ-ын орлого, хэрэглэгчийн ангиллаар**

Орлогын ангилал	Хэмжээ, сая.төг
<b>Нийт орлого</b>	<b>125,395.1</b>
ҮААНБайгууллагын орлого	61,058.5
Айл өрхийн орлого	36,113.1
Бөөний борлуулалтын орлого	24,317.5
Бусад орлого	3,906.0

**Зураг 15. Орлогын бүтэц, хэрэглэгчийн төрлөөр**




**3.2. Үйл ажиллагааны зардал**

Тайлант хугацаанд салбарын дүнгээр 284.4 тэрбум төгрөгийн зардалтай ажиллаж, нийт зардал урд оныхоос 49.7 тэрбум төгрөгөөр буюу 21.2 хувиар нэмэгджээ.

**Хүснэгт 10. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны зардал, сая төг.**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2012 он	2013 он
Ус сувгийн удирдах газар	32,397.8	36,946
УБ хотын ОНӨААТҮГ-ууд	44,754.6	56,360
Хувийн хэвшлийн компаниуд	929.0	12,735
Аймаг, орон нутгийн байгууллагууд	39,653.0	61,351
Уул уурхайн харъяа тусгай зөвшөөрөл эзэмшигчид	14,398.8	24,541
<b>Нийт дүн</b>	<b>132,133.2</b>	<b>191,935.8</b>



Нийт зардлын 30.1 хувийг аймаг, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагууд, 25.8 хувийн Улаанбаатар хотын ОНӨААТҮГ-ууд, 17.2 хувийг УСУГ, 14.3 хувийг хувийн хэвшлийн байгууллагууд, үлдэх 12.7 хувийг уул уурхайн харъяа ТЗЭ байгууллагуудын зардал бүрдүүлж байна. Зардлын бүтцийг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний зардал 47.7 хувь, дулааны зардал 35.7 хувь, бусад зардал 16.6 хувийг эзэлжээ (Зураг 16).

**Зураг 16. Зардлын бүтэц, үйл**

**ажиллагааны төрлөөр**

ТЗЭ байгууллагууд 2015 онд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээнд 135.55 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан нь 2014 оноос 19.3 тэрбум төгрөг буюу 16.6 хувиар нэмэгджээ (Хүснэгт).

**Хүснэгт 11. УХАТ-ын ашиглалт үйлчилгээний зардал, сая төг.**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2012 он	2013 он	2014 он	2015 он	Өсөлт +/- Бууралт +/-
Ус сувгийн удирдах газар	32,397.7	36,946.9	41,989.3	48,790.5	6,801.2
УБ хотын ОНӨААТҮГ-ууд	11,493.1	15,235.6	17,658.8	21,655.5	3,996.7
Хувийн хэвшлийн компаниуд	1,062.3	2,178.9	5,731.9	9,282.8	3,550.9
Аймаг, орон нутгийн байгууллагууд	21,869.1	26,069.9	30,104.4	34,095.3	3,990.9
Уул уурхайн харъяа тусгай зөвшөөрөл эзэмшигчид	14,398.8	23,214.8	20,736.3	21,723.1	-2,478.5
<b>Нийт дүн</b>	<b>81,221.0</b>	<b>103,646.1</b>	<b>116,220.6</b>	<b>135,547.2</b>	<b>15,861.2</b>

ТЗ-ийн үйл ажиллагааны нийт зардлын 36.0 хувийг УСУГ-ын, 16.0 хувийг Улаанбаатар хотын бусад ОНӨААТҮГ-ын, 13.3 хувийг аймг, орон нутгийн ТЗЭ байгууллагуудын, 6.8 хувийг хувийн хэвшлийн, 25.2 хувийг аймаг, орон нутгийн, 16.0 хувийг уул уурхайн харъяа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зардал тус тус эзэлсэн (Зураг 17).

**Зураг 17. Зардлын бүтэц, ТЗЭ-ийн төрлөөр**

Улаанбаатар хотын “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ 2015 онд 48.79 тэрбум төгрөгийн зардалтай ажиллан зардал өмнөх оноос 6.8 тэрбум төгрөгөөр буюу 16.2 хувиар нэмэгджээ.


Нийслэлийн бусад ОНӨААТҮГ-ууд 2015 онд ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны зардлаа өмнөх оноос 22.6 хувиар нэмэгдүүлж, 21.66 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан байна. Зардлын өсөлтөд эрчим хүчний тарифын өсөлт болон үйлчилгээний хүрээ нэмэгдсэн нь голчлон нөлөөлжээ.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, Улаанбаатар хотын хувийн хэвшлийн компаниудын зардал 9.28 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 62.0 хувиар нэмэгдсэн харагдаж байгаа нь тайлан мэдээ ирүүлэлт сайжирсантай холбоотой. Хувийн хэвшлийн компаниудын хувьд ихэвчлэн тодорхой стратеги, төлөвлөгөө гарган ажилладаггүй нийтлэг дутагдал үргэлжилсээр байна.

Аймаг, орон нутгийн байгууллагууд 2015 онд ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны зардлаа өмнөх оноос 13.3 хувиар нэмэгдүүлж, 34.1 тэрбум төгрөгийн зардал гаргасан байна. Зардлын өсөлтөд эрчим хүчний тарифын өсөлт болон хэрэглэгчийн тоо нэмэгдсэн нь голчлон нөлөөлжээ.

Уул уурхайн харъяа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зардал 21.72 тэрбум төгрөг болсон нь "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ий Эрчим хүчний цех 2015 онд 20.1 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан нь зардлын 92.7 хувь болжээ. "Энержи интернэшнл" ХХК, "Ухаа худаг ус хангамж" ХХК-нуудын зардал үйл ажиллагааны сааталтай холбоотойгоор буурсан байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны зардлын бүтцийг авч үзвэл цалин, НДШ-ийн зардал хамгийн өндөр буюу 31.2 хувийг эзэлж байгаа бол ашиглалтын зардалд 19.3 хувь, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд 16.7 хувь, засвар үйлчилгээнд дөнгөж 2.1 хувийг нь зарцуулсан байна (Зураг 18).



**Зураг 18. ТЗЭ байгууллагуудын УХАТ-ын үйлчилгээний зардлын бүтэц, 2015 он**

Зардлын бүтцээс үзэхэд цалин, цахилгаан, элэгдэл, ус худалдан авах, бохир ус нийлүүлэх гэсэн үндсэн 4 төрлийн зардал нийт зардлын 80.4 хувийг эзэлж байна. Хэдийгээр нийт зардалд эзлэх цалингийн зардал өндөр байгаа боловч дундаж цалин улсын доогуур байгаа юм.

Усны үйлчилгээний тариф бодит өөрийн өртгөөс доогуур тогтоогдож байгаагаас тоног төхөөрөмж, шугам сүлжээний засвар үйлчилгээ шаардлагын түвшинд хийгдэхгүй, ажиллагсдын цалин доогуур, нийгмийн зардалд зарцуулах хөрөнгө хангалтгүй байх, үйлчилгээний чанар муудах нөхцлийг үүсгэж байна. Иймд Зохицуулах зөвлөлөөс цаашид тарифт цаг алдалгүй зохицуулалт хийх, шат дараатайгаар өртгөө нөхөх түвшинг дээшлүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.

### 3.3. Ашиг, алдагдал

2015 онд салбарын байгууллагууд үйл ажиллагаанаасаа нийт 36.06 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн нь алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 31.87 тэрбум төгрөгөөр нэмэгджээ (Хүснэгт 12).

#### Хүснэгт 12. Нийтийн аж ахуйн байгууллагуудын ашиг, алдагдал, сая төг.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2012 он	2013 он	2014 он	2015 он	Өсөлт +/- Бууралт -/
Ус сувгийн удирдах газар	(7,285.4)	(10,108.3)	(4,807.09)	(3,654.00)	1,153.1
УБ хотын ОНӨААТҮГ-ууд	(6,865.6)	(10,506.6)	(3,217.13)	(5,217.40)	(2,000.3)
Хувийн хэвшлийн компаниуд	(157.2)	18.4	17,715.71	(513.20)	(18,228.9)
Аймаг, орон нутгийн байгууллагууд	(2,119.2)	(7,362.8)	(12,981.65)	(14,890.90)	(1,909.2)
Уул уурхайн харьяа тусгай зөвшөөрөл эзэмшигчид	(29.5)	1,140.4	(900.89)	(11,785.80)	(10,884.9)
<b>Нийт дүн</b>	<b>(16,456.9)</b>	<b>(26,818.8)</b>	<b>(4,191.1)</b>	<b>(36,061.3)</b>	<b>(31,870.2)</b>

Ийнхүү алдагдал эрс нэмэгдэх үндсэн шалгаан нь эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор хувийн хэвшлийн компаниудын эрхэлдэг бусад чиглэлийн буюу барилга угсралт, уул уурхайн үйл ажиллагааны орлого эрс буурсан явдал юм. Тухайлбал, ТЗ эзэмшигч хувийн компаниуд 2014 онд ашигтай ажиллаж байсан бол 2015 онд 513.2 сая төгрөгийн алдагдал хүлээжээ. Уул уурхайн харьяа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн алдагдал 10.88 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Харин тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны хүрээнд мөн онд 10.15 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан нь өмнөх оныхоос алдагдал даруй 6.65 тэрбум төгрөгөөр буюу 39.6 хувиар буурсан байна (Хүснэгт 13).

#### Хүснэгт 13. Тусгай зөвшөөрлийн хүрээнд ашиг, алдагдал, сая төг.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2012 он	2013 он	2014 он	2015 он	Өсөлт +/- Бууралт -/
Ус сувгийн удирдах газар	(7,285.3)	(10,108.3)	(5,325.6)	(3,654.0)	4,782.7
УБ хотын ОНӨААТҮГ-ууд	(1,017.7)	(1,410.5)	(1,083.9)	(63.4)	326.5
Хувийн хэвшлийн компаниуд	(290.5)	(88.8)	(2,028.1)	(1,547.5)	(1,939.3)
Аймаг, орон нутгийн байгууллагууд	(1,876.3)	(4,257.5)	(6,311.9)	(2,817.9)	(2,054.4)
Уул уурхайн харьяа тусгай зөвшөөрөл эзэмшигчид	(369.7)	1,634.9	(2,049.6)	(2,069.4)	(3,684.5)
<b>Нийт дүн</b>	<b>(10,839.5)</b>	<b>(14,230.1)</b>	<b>(16,799.0)</b>	<b>(10,152.2)</b>	<b>(2,568.9)</b>

Алдагдлын зонхилох хувь УСУГ болон аймаг, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагуудад ногдож байна. Ийнхүү алдагдал буурч байгаа нь цаашид усны үйлчилгээний тарифын тогтолцоог боловсронгуй болгон ТЗЭ-ийн тарифын зохицуулалтыг оновчтой хийснээр салбарын байгууллагууд хэвийн ажиллах боломж бүрдэж байгааг харуулж байна.

Улаанбаатар хотын “УСУГ” ОНӨААТҮГ үйл ажиллагаанаасаа 5.5 тэрбум төгрөг тусгай зөвшөөрлийн хүрээнд 3.65 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд 2015 оны 9 дүгээр сард тарифын зохицуулалт хийснээр алдагдал өмнөх он (5.33 тэрбум төгрөг)-

оос 1.67 тэрбум төгрөгөөр буюу 31.4 хувиар буурчээ. УСУГ-ын алдагдал нь УХАТ-ын үйл ажиллагааны нийт алдагдлын 36.0 хувийг эзэлж байна.

Тайлант онд тусгай зөвшөөрлийн хүрээнд Улаанбаатар хотын ОНӨААТҮГ-уудын алдагдал 63.4 сая төгрөг болж 2014 оныхоос 1.02 тэрбум төгрөг буюу 94.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Түүнчлэн Улаанбаатар хотын орон сууц нийтийн аж ахуйн хувийн хэвшлийн компаниудын алдагдал тусгай зөвшөөрлийн хүрээнд 1.55 тэрбум болж өмнөх оноос 23.7 хувь буурсан боловч алдагдалтай ажилласан аж ахуйн нэгжүүдийн тоо нэмэгджээ. Хэрэглэгчийн тоо цөөн, үйлчилгээний хамрах хүрээ багатай зэрэг нь хувийн хэвшлийн байгууллагууд алдагдалтай ажиллах үндсэн шалтгаан болж байна.

Аймаг, орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд УХАТ-ын үйл ажиллагаанаасаа 2014 онд 6.31 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол 2015 онд 2.82 тэрбум төгрөг болж алдагдал 55.4 хувиар буурсан байна. Энэ нь орон нутагт суурь хураамжийг хэрэгжүүлж, цэвэр, бохир усны үйлчилгээний тарифын зохицуулалт хийснээс голлон шалтгаалжээ.

Тусгай зөвшөөрлийн хүрээнд уул уурхайн харъяа тусгай зөвшөөрөл эзэмшигчид 2.07 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн нь өмнөх онтой харьцуулахад алдагдал 19.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Салбарын байгууллагуудын хэмжээнд хуримтлагдсан алдагдал 156.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оноос 17.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Түүнчлэн ТЗЭ байгууллагууд элэгдлийн сангаа бодитойгоор байгуулж чадахгүй байгаагаас бие даан их засвар, шинэчлэл хийх боломжгүй байдалд орж, улс, орон нутгийн төсөв, олон улсын зээл, тусламжаас ихээхэн хамааралтай хэвээр байна.

Хэдийгээр 2014 оноос эхлэн усны үйлчилгээний тарифын зохицуулалтыг шат дараатайгаар хэрэгжүүлж байгаа боловч өмнө нь үнийг удаан хугацааны турш нэг түвшинд барьсаас үүссэн санхүүгийн хүндрэлийг нэг мөр шийдвэрлэх боломжгүй юм. Цаашид тарифын зохицуулалтыг макро эдийн засгийн нөхцөл байдалтай нягт уялдуулан цаг хугацаанд хийж байх шаардлагатай байна.

### **3.4. Авлага, өр төлбөр**

#### **Авлага**

Хот, суурины ус хангамж ариутгах, татуургын ашиглалт, үйлчилгээ хариуцсан тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд нь 2015 онд нийтдээ 31.2 тэрбум төгрөгийн авлагатай ажиллаж, авлага өмнөх оноос 21.3 тэрбум төгрөгөөр буюу 40.6 хувиар буурсан байна. Хувийн хэвшлийн компаниудын авлага 22.2 тэрбумаар буурсан нь үүнд гол нөлөө үзүүлжээ.

Тайлант хугацаанд “УСУГ” ОНӨААТҮГ-ын авлага 584.3 сая төгрөг буюу 10.5 хувиар нэмэгдэж 6.16 тэрбум төгрөгт хүрчээ. Улаанбаатар хотын ОСНААУГ зэрэг бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч ОНӨААТҮГ-ын авлага 419.7 сая төгрөгөөр буюу 30.5 хувиар нэмэгдсэн байна. Ийнхүү авлага нэмэгдсэн нь эдийн засгийн байдал хүндэрч байгаатай холбоотой гэж үзэж байна.

Улаанбаатар хотын хувийн хэвшлийн компаниудын авлага 22.2 тэрбум төгрөг буюу 72.5 хувиар буурч 8.4 тэрбум төгрөг болсон он дамжсан барилгын ажлын санхүүжилтийн гүйцэтгэлээс шалтгаалжээ.



**Хүснэгт 14. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн авлага, сая төг.**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2013 он	2014 он	2015 он	Өөрчлөлт	
				хэмжээ +, -	хувь %
Ус сувгийн удирдах газар	4,359.5	5,578.1	6,162.4	584.3	10.5%
УБ хотын ОНӨААТҮГ-ууд	930.9	1,374.7	1,794.4	419.7	30.5%
Хувийн хэвшлийн компаниуд	4,637.7	30,627.2	8,427.0	-22,200.2	-72.5%
Аймаг, орон нутгийн байгууллагууд	12,323.6	14,856.9	14,781.7	-75.2	-0.5%
<b>Нийт дүн</b>	<b>22,251.7</b>	<b>52,436.9</b>	<b>31,165.4</b>	<b>-21,271.5</b>	<b>-40.6%</b>

Аймаг, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагуудын авлага 14.78 тэрбум төгрөг болсон нь өмнөх оныхоос 75.2 сая төгрөгөөр буурсан байна. "Дархан ус суваг" ХК 1.3 тэрбум төгрөг, "Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ" ОНӨХК-ийн 1.5 тэрбум төгрөг, "Гавшгай ус" ХХК 1.0 тэрбум төгрөг, "Чандмань Илч" ХХК 1.3 тэрбум төгрөг, Түүнчлэн "Дөрвөлж" ХХК 1.6 тэрбум төгрөг, "Чандмань Налайх" ОНӨААТҮГ 797 сая төгрөгийн авлагатай байгаа нь аймаг, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагуудын нийт авлагын 51 хувийг эзэлсэн байна.

**Өр төлбөр**

Тайлан оны жилийн эцсийн байдлаар уул уурхайн компаниудыг оруулахгүйгээр тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын өр төлбөрийн нийт хэмжээ 235.86 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 91.13 тэрбум төгрөгөөр буюу 27.9 хувиар буурсан байна (Хүснэгт 15).

**Хүснэгт 15. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн өр төлбөр, сая төг.**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2013 он	2014 он	2015 он	Өөрчлөлт	
				хэмжээ +, -	хувь %
Ус сувгийн удирдах газар	110,625.7	124,042.1	130,600.4	6,558.3	5.3%
УБ хотын ОНӨААТҮГ-ууд	33,644.4	31,694.1	31,860.8	166.7	0.5%
Хувийн хэвшлийн компаниуд	6,046.8	86,957.6	8,793.1	-78,164.5	-89.9%
Аймаг, орон нутгийн байгууллагууд	42,337.8	84,303.9	64,610.4	-19,693.5	-23.4%
<b>Нийт дүн</b>	<b>192,654.7</b>	<b>326,997.7</b>	<b>235,864.7</b>	<b>-91,133.0</b>	<b>-27.9%</b>

**Хүснэгт 16. Өр төлбөрийн бүтэц**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	Богино хугацаат өр төлбөр		Урт хугацаат өр төлбөр		Өр төлбөрийн дүн	
	Хэмжээ, сая.төг	Дүнд эзлэх хувь %	Хэмжээ, сая.төг	Дүнд эзлэх хувь %	Хэмжээ, сая.төг	Нийт дүнд эзлэх %
Ус сувгийн удирдах газар	676.7	0.5	129,923.8	99.5	130,600.4	55.4
УБ хотын ОНӨААТҮГ-ууд	4,721.5	14.8	27,139.3	85.2	31,860.8	13.5
Хувийн хэвшлийн компаниуд	8,707.0	99.0	86.2	1.0	8,793.1	3.7
Аймаг, орон нутгийн байгууллагууд	33,124.3	51.3	31,486.1	48.7	64,610.4	27.4
<b>Нийт</b>	<b>47,229.4</b>	<b>20.0</b>	<b>188,635.3</b>	<b>80.0</b>	<b>235,864.7</b>	<b>100</b>

Улаанбаатар хотын "УСУГ" ОНӨААТҮГ-ын өр төлбөр 130 тэрбум төгрөгт хүрч, нийт өрийн 55.4 хувийг эзэлж байна. Ус сувгийн удирдах газар нь гэр хорооллын ус хангамжийг төвлөрсөн сүлжээнд холбох, цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, орон нутагт НАА-н салбарыг хөгжүүлэх төслүүдийн хүрээнд урт хугацааны хөнгөлөлттэй зээлийг

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын банк санхүүгийн байгшууллагаас дамжуулан зээлдүүлэх гэрээтэй авсан бөгөөд 2015 оны үнээр үндсэн зээл 98 тэрбум, зээлийн хүү 31.92 тэрбум төгрөг болжээ. Одоогийн байдлаар энэхүү зээлийн хүүгийн төлбөрийг тарифт тусгах боломжгүй байгаа тул зээлийн эргэн төлөлтийн асуудлыг гэрээнд оролцогч талууд яаралтай хамтран шийдвэрлэх шаардлага тулгараад байна.

Улаанбаатар хотын ОНӨААТҮГ-ууд нь 2015 онд 31.9 тэрбум төгрөгийн өр төлбөртэй болж өр төлбөр өмнөх оноос 166 сая төгрөгөөр өсжээ. Нийт өрийн 85.2 хувь буюу 27.1 тэрбум төгрөг нь урт хугацаат зээл болно.

Орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд 2015 оны жилийн эцсийн байдлаар 64.6 тэрбум төгрөгийн өр төлбөртэй гарсан нь өмнөх оныхоос 19.7 тэрбум төгрөгөөр буюу 23.4 хувиар буурсан байна. Нийт өрийн 51.3 хувь нь богино хугацаат, үлдэх 48.7 хувь нь урт хугацаат өр төлбөр болно.

Түүнчлэн "ОСНААУГ" ОНӨААТҮГ болон зарим аймгуудын тусгай зөвшөөрөл эзэмшигчид олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын орон нутгийн НАА-г сайжруулах хөнгөлөлттэй зээлд хамрагдан, эргэн төлөлт хийж чадахгүй байгаагаас ийнхүү урт хугацаат өр төлбөрийн хэмжээ буурахгүй байна. Аймгуудын НАА-н байгууллагуудаас "Гүний ус" ХХК нь өөрийн балансад төлөх ёстой урт хугацаат зээлийн хүүг богино хугацаат зээлийн хүүгийн өр, үндсэн зээлийн төлбөрийг богино хугацаат өглөгөөр тусгаж байгаа бол бусад байгууллага ямар нэгэн өөрчлөлт тусгаагүй явж иржээ.

Богино хугацаат өр төлбөрийн дийлэнх буюу 90 гаруй хувийг "Чандмань Налайх" ОНӨААТҮГ-ын 1.8 тэрбум, "Дулаан шарын гол" ТӨХК-ий 1.0 тэрбум, "Дархан ус суваг" ХК-ий 1.1 тэрбум, "Гавшгай ус" ХХК-ий 1.1 тэрбум, " "Эрдэнэт ус.ДТС" ОНӨХК-ий 2.27 тэрбум, "Гүний ус" ХХК-ий 1.0 тэрбум, "Ухаа худаг ус хангамж" ХХК-ий 14.6 тэрбум, "Чандмань Илч" ХХК-ий 1.5 тэрбум төгрөг, "Дөрвөлж" ХХК-ий 4.5 тэрбум төгрөгийн өр зээлсэн байна.

2015 онд Улаанбаатар хотын хувийн хэвшлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын өр төлбөр 89.9 хувиар буурч 8.8 тэрбум төгрөг болсон байна. Өр төлбөрийн дийлэнх буюу 8.7 тэрбум төгрөг нь богино хугацаат өр төлбөр байна.

Судалгаанаас үзэхэд хувийн хэвшлийн байгууллагуудад богино хугацаат өр төлбөр зонхилж байгаа бол орон нутгийн өмчит байгууллагуудад урт хугацаат зээлийн өр төлбөр зонхилж байна.

Нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх зорилгоор олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан урт хугацаат зээл, түүний зээлийн хүүг төлөх хугацаа болсон хэдийч салбарын байгууллагууд алдагдалтай ажиллаж, бодит зардлаа нөхөх чадваргүй байгаагаас өр төлбөрөө төлөх боломж одоог хүртэл бүрдэж чадахгүй байна.

## **Дөрөв. Бусад үзүүлэлт**


Зохицуулах зөвлөлөөс Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үйлчилгээний чанарыг сайжруулах, үр ашиг, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор 2014 оноос ус хангамжийн тасалдал, хэрэглэгчдийн гомдолын талаар тайлан мэдээг гаргуулан, харьцуулсан судалгаа хийж эхэлсэн.

## 4.2. Цэвэр ус хангамжийн тасалдал

2015 онд ус хангамжийн тасалдлын тайлан мэдээг нийт 75 Тусгай зөвшөөрөл эзэмшигч маягтын дагуу ирүүлсэн нь өмнөх оноос 2.1 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 17. Усны тасалдлын мэдээ, 2015 он

Үзүүлэлт	Хэмжээ
Усны тасалдалд хамрагдсан хэрэглэгчийн тоо	566,383
Нийт тасалдал - цагаар	14,115
Төлөвлөгөөт засвараар	2,248
Шугам сүлжээний гэмтлээс	10,981
Байгалын гамшиг нөлөөгөөр	53
Гуравдагч этгээдийн нөлөөгөөр	516
Бусад шалтгаанаар	317



Зураг 19. Усны тасалдал - хувиар

Ус тасалдлын мэдээнээс үзэхэд 2015 онд нийт 566.4 мянган хэрэглэгчийн ус 14.1 мянган цаг тасарснаас 10.9 мянган цаг нь шугам сүлжээний гэмтлээс болж тасарсан байна. Энэ нь нийт ус тасалдсан цагийн 78 хувь болж байна.

Цаашид энэ үзүүлэлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигч бүрээр гаргуулан харьцуулсан судалгаа хийх шаардлагатай юм.

## 4.3. Хэрэглэгчийн санал гомдол, засвар үйлчилгээ үзүүлсэн судлагаа


2015 онд хэрэглэгчийн санал, гомдол, дуудлагын засвар үйлчилгээний тайлан мэдээг нийт 71 Тусгай зөвшөөрөл эзэмшигч маягтын дагуу ирүүлсэн нь өмнөх оныхоос тайлан ирүүлэлт 54.4 хувиар нэмэгдсэн байна.

Тэдгээрийн дүнгээр нийт 82289 дуудлага, санал ирснээс 82091 дуудлага, саналыг хугацаанд нь шийдвэрлэж, санал гомдлыг 99.8 хувиар барагдуулжээ.

Хүснэгт 18. Хэрэглэгчийн дуудлага, санал гомдол, 2015 он

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ангилал	Усны тасалдал		Усны чанар		Төлбөр тооцоо		Засвар үйлчилгээ		Харилцааны соёл		Хэрэглэгчийн дуудлагын дүн	
	Ирсэн	Шийдвэр лэсэн	Ирсэн	Шийдвэр лэсэн	Ирсэн	Шийдвэр лэсэн	Ирсэн	Шийдвэр лэсэн	Ирсэн	Шийдвэр лэсэн	Ирсэн	Шийдвэр лэсэн
Орон нутгийн байгууллага	880	862	154	146	676	640	28,800	28,719	198	183	30,708	30,550
Улаанбаатар хотын ОНӨААТҮГ-ууд	286	286	51	51	85	85	166	166	141	141	729	729
Хувийн хэвшлийн компаниуд	3,054	3,054	4,306	4,286	3,759	3,754	37,560	37,545	2,173	2,173	50,852	50,812
<b>Бүгд</b>	<b>4,220</b>	<b>4,202</b>	<b>4,511</b>	<b>4,483</b>	<b>4,520</b>	<b>4,479</b>	<b>66,526</b>	<b>66,430</b>	<b>2,512</b>	<b>2,497</b>	<b>82,289</b>	<b>82,091</b>

Цаашид дээрх үзүүлэлтүүдийн ач холбогдлыг дээшлүүлэх, салбарын мэдээ мэдээллийг үнэн зөв гаргах үүднээс нийт ТЗЭ-чид ус хангамжийн тасалдлын болон хэрэглэгчийн дуудлага, санал, гомдлын мэдээг шалтгаан бүрээр тодорхой бүртгэл хөтөлж, хугацаандаа тайлагнаж байх шаардлагатай байна.



Зураг 20. Хэрэглэгчийн дуудлага-санал, хувиар

## Тав. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

Зохицуулах зөвлөлөөс ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, хяналт тавих, гүйцэтгэлийн үзүүлэлтийг харьцуулах, тэдгээрийн үйлчилгээний чанарын түвшинг тодорхойлох, олон улсын стандартад ойртуулах, удирдлагын шийдвэр гаргахад дэмжлэг болгох, олон нийтэд үйл ажиллагааг нь таниулан нээлттэй ажиллах зорилгоор 2012 оноос эхлэн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг гаргаж ирлээ.

Энэ үзүүлэлтүүд жил ирэх бүр тоо, чанарын хувьд боловсронгуй болж, ТЗЭ-чид өөрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх боломжтой болж байна. 5 дугаар бүлэгт УХАТ-ын үйлчилгээний санхүү эдийн засгийн үзүүлэлттэй холбогдох зарим гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг салбарын дүнгээр гарган дүгнэсэн бөгөөд байгууллага нэг бүрээр хавсралт 1, 2-т тус тус үзүүлэв.

### 5.1. Орлогын 1 төгрөгт ногдох зардал


Хүснэгт 19. Орлогын 1 төгрөгт ногдох зардлын үзүүлэлт – 2015 он

Ангилал	Нийт зардал сая.төг	Нийт орлого сая.төг	Зонтн
Аймаг, орон нутгийн байгууллагууд	56,585.7	50,931.1	1.11
УБ хотын ОНӨААТҮГ	70,446.0	66,728.6	1.06
Хувийн хэвшлийн компаниуд	9,282.8	7,735.4	1.20
<b>Салбарын дүнгээр</b>	<b>136,314.5</b>	<b>125,395.1</b>	<b>1.09</b>

Улсын дунджаар УХАТ-ын үйлчилгээний орлогын нэг төгрөгт 1.09 төгрөгийн зардал ногдож байгаа бөгөөд энэ үзүүлэлт Улаанбаатар хотын ОНӨААТҮГ-уудын дүнгээр 1.06 байгаа бол хувийн хэвшлийн компаниудынх 1.20 төгрөг байсан байна.

Ийнхүү хувийн хэвшлийн байгууллагуудын орлогын нэг төгрөгт ногдох зардал өндөр байгаа нь хэрэглэгчийн тоо цөөн буюу үйл ажиллагааны цар хүрээ багатай салшгүй

холбоотой. Цаашид алдагдлаа бууруулахын тулд юуны өмнө зардлаа хянаж ажиллах шаардлагатайн дээр хэрэглэгчийн тоогоо нэмэгдүүлэх хэрэгтэй юм. Түүнчлэн байршил ойролцоо аж ахуйн нэгжүүд хоорондоо нэгдэх боломжийг эрэлхийлэн, аль болох үр өгөөжтэй ажиллах шаардлагатай байна.



**Зураг 21. Орлогын 1 төгрөгт ногдох зардал -2015 он, нийт дүнгээр болон УХАТ-ын дүнгээр**

Орон нутгийн аж ахуйн нэгжүүд болон нийслэлийн ТЗЭ-дийн орлогын нэг төгрөгт ногдох зардал байгууллагын дүнгээр УХАТ-ын үйлчилгээнийхээс өндөр байхад хувийн хэвшлийн компаниуд УХАТ-ын үйлчилгээнд зардал өндөртэй ажилласан байна.

## 5.2. Борлуулсан 1 м<sup>3</sup> усанд ногдох үйл ажиллагааны зардал

Тайлант онд салбарын дунджаар нэгж бүтээгдэхүүнд ногдох зардал цэвэр усанд 827 төг/м<sup>3</sup> гарсан нь өмнөх оноос 109.4 төгрөг буюу 15.3 хувиар, бохир усанд 458.7 төг/м<sup>3</sup> гарсан нь өмнөх оноос 89.3 төгрөг буюу 24.2 хувиар тус тус өссөн байна.

**Хүснэгт 20. 1 м<sup>3</sup> усанд ногдох үйл ажиллагааны зардал - 2015 он**

Ангилал	Борлуулсан цэвэр ус мян.м <sup>3</sup>	Цэвэр усны зардал сая.төг	Цэвэр ус, төг/м <sup>3</sup>	Татан зайлуулсан бохир ус мян.м <sup>3</sup>	Бохир усны зардал сая.төг	Бохир ус, төг/м <sup>3</sup>
Аймаг, орон нутгийн байгууллагууд	45,570.1	40,303.5	<b>884.4</b>	17,477.2	16,282.2	<b>931.6</b>
УБ хотын ОНӨААТҮГ	63,735.0	49,312.2	<b>773.7</b>	63,375.7	21,133.8	<b>333.5</b>
Хувийн хэвшлийн компаниуд	6,854.4	6,445.8	<b>940.4</b>	6,903.3	2,837.0	<b>411.0</b>
<b>Салбарын дүнгээр</b>	<b>116,159.5</b>	<b>96,061.5</b>	<b>827.0</b>	<b>87,756.2</b>	<b>40,253.0</b>	<b>458.7</b>

Ийнхүү зардал өссөн нь цалингийн өсөлт, эрчим хүчний болон ус худалдан авалтын үнийн өсөлтөөс шалгаалжээ. Борлуулсан 1 м<sup>3</sup> усны зардал буюу 1 м<sup>3</sup> усны өртөг Улаанбаатар хотын ОНӨААТҮГ-уудын дунджаар хамгийн бага байгаа бол аймаг, орон нутагт хамгийн өндөр байна. Энэ нь өртөг хэрэглэгчийн тоо буюу үйлчилгээний хэмжээнээс хамааралтай байгааг харуулж байна.

## 5.3. Эргэлтийн харьцаа

Эргэлтийн харьцаа нь богино хугацаат өр төлбөрөө эргэлтийн хөрөнгөө ашиглан төлөх чадвар ямар байгааг илэрхийлдэг. Энэ харьцаа 2-той ойрхон байх нь тохиромжтой гэж үздэг бөгөөд ТЗ эзэмшигчдээс хувийн компаниудын энэ үзүүлэлт харьцангуй боломжийн байна (Хүснэгт 21).

**Хүснэгт 21. Эргэлтийн харьцааны үзүүлэлт – 2015 он**

Ангилал	Эргэлтийн хөрөнгө сая.төг	Өр төлбөр сая.төг	Эхарьц
Аймаг, орон нутгийн байгууллагууд	27,737.7	64,610.4	<b>0.43</b>
УБ хотын ОНӨААТҮГ	30,113.5	162,461.2	<b>0.19</b>
Хувийн хэвшлийн компаниуд	14,605.8	8,793.1	<b>1.66</b>
<b>Салбарын дүнгээр</b>	<b>72,457.0</b>	<b>235,864.7</b>	<b>0.31</b>

**5.4. Төлбөр гүйцэтгэх чадварын харьцаа**

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нь өр төлбөрөө хөрвөх чадвар сайтай хөрөнгүүд ашиглан төлөх чадварыг илэрхийлдэг бөгөөд 1-ээс их байх нь тохиромжтой гэж үздэг. Салбарын дүнгээр энэ үзүүлэлт доогуур байгаа боловч хувийн хэвшлийн компаниудын дундажаар хэвийн үзүүлэлт гарсан байна.

**Хүснэгт 22. Төлбөр гүйцэтгэх чадварын харьцааны үзүүлэлт – 2015 он**

Ангилал	Түргэн хөрвөх хөрөнгө, сая.төг.	Өр төлбөр, сая.төг.	ТГЧхарьц
Орон нутгийн ТЗЭ байгууллага	17,716.0	64,610.4	<b>0.27</b>
УБ хотын НӨААТҮГ	23,415.3	162,461.2	<b>0.14</b>
УБ хотын Хувийн хэвшлийн ТЗЭ	11,072.2	8,793.1	<b>1.26</b>
<b>Салбарын нийт дүнгээр</b>	<b>52,203.5</b>	<b>235,864.7</b>	<b>0.22</b>

**5.5. Үйл ажиллагааны ашгийн норм**

Ашгийн норм буюу үйл ажиллагааны ахиуц ашиг нь үйл ажиллагааны зардлуудыг төлсний дараагаар үлдэж буй борлуулалтын орлогын хэсгийг харуулна. 2015 оны дүнгээр салбарын байгууллагууд алдагдалтай ажиллаж ашгийн норм хасах 0.09 байв (Хүснэгт 23).

**Хүснэгт 23. Үйл ажиллагааны ашгийн норм – 2015 он**

Ангилал	Ашиг, алдагдал сая.төг	Борлуулалтын орлого, сая.төг	Ашгийн норм
Аймаг, орон нутгийн байгууллагууд	-5,654.6	50,931.1	<b>-0.11</b>
УБ хотын ОНӨААТҮГ	-3,717.4	66,728.6	<b>-0.06</b>
Хувийн хэвшлийн компаниуд	-1,547.5	7,735.4	<b>-0.20</b>
<b>Салбарын дүнгээр</b>	<b>-10,919.4</b>	<b>125,395.1</b>	<b>-0.09</b>

**ДҮГНЭЛТ**

1. 2015 онд нийт 145 байгууллага ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 30.3 хувь нь буюу 44 хөдөө орон нутагт, 69.7 хувь нь буюу 101 нь Улаанбаатар хотод байршиж байна.

2. Сүүлийн жилүүдэд салбарт хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэн 2015 онд 61 хувийн компани ТЗ эзэмших болсон нь өмнөх оноос 35.6 хувиар өсчээ.

3. Тайлант онд нийт 100 тусгай зөвшөөрөл эзэмшигч тайлан мэдээгээ ирүүлэх байснаас 98 байгууллага тайлан ирүүлснээр тайланд хамрагдалт 98 хувьд хүрсэн байна. Зарим байгууллага тайлан, мэдээгээ хоцроох буюу дутуу ирүүлж байгаа нь хяналт шинжилгээ хийхэд хүндрэл учруулж, цаг алдахад хүргэж байгааг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааран цаашид дүн мэдээгээ цаг хугацаанд ирүүлэх шаардлагатай юм.

4. 2015 онд ТЗЭ байгууллагууд хот, суурины ус хангамжид зориулан 101.6 сая м<sup>3</sup> олборлон боловсруулсан байна. Орлого болоогүй ус 19.08 сая м<sup>3</sup> буюу 18.8 хувь байв. Энэ нь өмнөх оноос 0.78 сая.м<sup>3</sup> –ээр өсчээ.

5. Усны чанарын шинжилгээгээр Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын ундны усанд магнийн агууламж стандарт утгаас хэтэрсэн, Булган аймаг “Булган мээж”, Орхон аймаг “Эрдэнэт үйлдвэр” ХХК, Дархан-Уул аймаг “Дулаан шарын гол” ТӨХК, “Дархан ус суваг” ХК, “Эмтнاران” ОНӨААТҮГ зэрэг байгууллагуудын ундны усанд амт, үнэрийн агууламж стандарт утгаас их, Говьсүмбэр аймгийн “Ус-Ду” ОНӨҮГ, Завханы “Амь-Ус трейд” ХХК зэрэг байгууллагуудын ундны усанд нянгийн тоо стандарт утгаас их гарсан тохиолдол илэрсэн байна. Энэ нь дээрх байгууллагууд усны эх үүсвэрийн ариутгал, халдваргүйжилтэнд анхаарах шаардлагатайг харуулж байна

6. Улсын хэмжээнд 125 бохир ус цэвэрлэх байгууламж байгаагаас үйл ажиллагаа нь хэвийн 51, хагас ажиллагаатай 27, үлдсэн нь ажиллагаагүй байна. Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын цэвэрлэх байгууламжийн 63 хувийг биологийн цэвэрлэгээтэй, 37 хувийг механик цэвэрлэгээ бүхий цэвэрлэх байгууламж эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн цэвэрлэгээний түвшин доогуур байна. Бохир усанд зөвхөн механик цэвэрлэгээ хийн карт руу хаяж байгаа нь хөрс, агаарын бохирдлыг нэмэгдүүлэх сөрөг нөлөө үзүүлж байна.

7. ТЗЭ аж ахуйн нэгжүүд 2015 онд нийт 87,756.2 мян.м<sup>3</sup> бохир ус татан зайлуулсан нь өмнөх оны мөн үеээс 3,260.7 мян.м<sup>3</sup> –ээр нэмэгджээ.

8. Хаягдал усан дах умбуур бодисын хэмжээ Улаанбаатар хот, Баян-Өлгий, Дундговь, Орхон, Хэнтий, Сэлэнгэ аймгийн Сайхан сумдын цэвэрлэх байгууламжийн хаягдал усанд стандартаас давсан бол Улаанбаатар, Налайх, Хэнтий, Сэлэнгэ аймгийн Сайхан суманд БХХ-ийн хэмжээ стандартаас давсан, Дундговь, Орхон, Хэнтий аймаг, Улаанбаатар хотод ХХХ-ийн агууламж стандартаас давсан үзүүлэлттэй байв. Ялангуяа Улаанбаатар хотын Төв цэвэрлэх цэвэрлэгээний түвшин буурч хүрээлэн буй орчинд нийлүүлж буй хаягдал бохир ус нь стандартын дээд хязгаараас давснаар байгаль орчин төдийгүй хүн амын эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах тул цэвэрлэгээний түвшинг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

9. 2015 оны жилийн эцсийн дүнгээр ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд нийт 500.63 мянган хэрэглэгчид үйлчилгээ үзүүлж байгаагаас 19.65 мянган хэрэглэгч буюу 3.9 хувь нь үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага, 229.06 мянга буюу 45.8 хувь нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон айл өрх, 251.92 мянган хэрэглэгч буюу 50.3 хувь нь зөөврийн усан хангамжтай байна.

10. Тайлант онд төвлөрсөн шугамд холбогдсон хэрэглэгчийн тоолууржилтын түвшин улсын дунджаар 79.8 хувьд хүрсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 5.3 пунктээр өсчээ. Тоолууржилтын түвшин нэмэгдэж байгаа боловч Улаанбаатар хотод төдийлөн ахицтай бус, ялангуяа орон сууцны айл орхийн тоолууржилт удаашралтай байна. Энэ нь ялангуяа хуучин орон сууцнуудад олон тоолуур хэрэгтэй болдог, шугам хоолой хэт хуучирсан зэрэгтэй холбоотойгоос гадна тоолуургүй хэрэглэгчийг ус хэрэглээний нормоор тооцдог

байдал үргэлжлэн, хангагч байгууллагын зүгээс тоолууржилтыг нэмэгдүүлэх сонирхлыг бууруулж байна.

11. Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэргэжлийн боловсон хүчний тухайд хүний нөөцийн бүрдүүлэлт улсын дунджаар 61.2 хувь байгаа нь 2013 оныхтой харьцуулахад 28 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ үзүүлэлт хөдөө, орон нутгийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын дунджаар 60.3 хувь, Улаанбаатар хотод дунджаар 62.0 хувьтай байв. Цаашид мэргэжлийн боловсон хүчнийг чаддавхжуулахад анхаарах, нийтийн аж ахуйн салбарын хүний нөөцийн бодлогыг боловсон хүчний эрэлт, нийлүүлэлттэй уялдуулж зөв зохистой удирдах шаардлага тулгарч байна

12. 2015 оны жилийн эцсийн мэдээгээр ТЗЭ байгууллагууд нийт 2.4 мянган км цэвэр усны шугам хоолой хариуцан ажиллаж байгаагаас 15 хувь нь 30-аас дээш жилийн насжилттай, 1.2 мянган км бохир усны шугамтайгаас 80 орчим хувь нь 30-40 жилийн насжилттай байна.

13. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 19.1-д заасны дагуу ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ улс болон орон нутгийн өмчинд байх ёстой боловч Улаанбаатар хотын захиргаанаас шугам сүлжээг өмчлөх асуудлыг удаашруулж байгаагаас хувийн хэвшлийн байгууллагуудын өмчлөлд байгаа цэвэр, бохир усны шугам сүлжээ нэмэгджээ. Цаашид хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

14. Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын мэргэжлийн хүний нөөцийн бүрдэлт улсын дунджаар 80.5 хувь, аймаг, орон нутгийн дундаж 86 хувь, УБ хотод дунджаар 75 хувьтай байна. Салбарт ажиллагсдын дундаж цалин 663.9 мянган төгрөг байгаа нь улсын дундаж (851.4 мян.төгрөг)-аас 22 хувиар бага байна. Цаашид салбарын боловсон хүчний асуудлыг онцгой анхааран цалин хөлсийг нэмэгдүүлж, нийгэм хангамжийг дээшлүүлэх нь чадварлаг мэргэжилтнүүдийг татах, салбарыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

15. Тайланд хамрагдсан нийтийн аж ахуйн салбарын байгууллагууд 2015 онд 248.3 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өмнөх оноос 7.7 хувиар, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанаас 125.9 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь өмнөх оноос 26.1 хувиар тус тус нэмэгджээ. Мөн онд нийт 284.4 тэрбум төгрөгийн зардалтай ажилласнаар зардал урд оныхоос 21.2 хувиар, тусгай зөвшөөрлийн хүрээнд 135.55 тэрбум төгрөгийн зардалтай ажилласнаар зардал 16.6 хувиар тус тус өссөн байна. Ийнхүү орлого, зардал өссөн нь цэвэр, бохир усны тариф нэмэгдэж, суурь хураамж нэвтрүүлсэн, шинэ бүтээн байгуулалтын үр дүнд хэрэглэгчийн тоо өссөн, цахилгаан, дулааны үнэ нэмэгдсэн болон бараа, материалын үнэ өссөн зэргээс шалтгаалсан байна.

16. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны зардлын бүтцийг авч үзвэл цалин, НДШ-ийн зардал хамгийн өндөр буюу 31.2 хувийг эзэлж байгаа бол ашиглалтын зардалд 19.3 хувь, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд 16.7 хувь, засвар үйлчилгээнд дөнгөж 2.1 хувийг нь зарцуулсан байна.

17. Салбарын алдагдал 10.2 тэрбум, хуримтлагдсан алдагдал 156.2 тэрбум төгрөг болж өнгөрсөн оныхоос өссөн байна. Хуримтлагдсан алдагдал нэмэгдэхэд УХАТ-аас бусад үйл ажиллагааны алдагдал голчлон нөлөөлсөн байна. Салбарын алдагдал өмнөх оноос



буурсан бөгөөд үүнд 2015 оны 1 дүгээр сараас эхлэн тарифын зохицуулалт хийсэн нь нааштай нөлөө үзүүлсэн байна.

18. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд нь 2015 онд нийтдээ 31.2 тэрбум төгрөгийн авлагатай ажиллаж, авлага өмнөх оноос 21.3 тэрбум төгрөгөөр буюу 40.6 хувиар буурсан байна.

19. Нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын өр төлбөрийн хэмжээ 235.86 тэрбум төгрөг, үүнээс урт хугацаат өр төлбөр 80 хувь буюу 188.64 тэрбум төгрөг байв. Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан урт хугацаат зээл, түүний зээлийн хүүг төлж эхлэх хугацаа болсон боловч салбарын байгууллагууд алдагдалтай ажиллаж, бодит зардлаа нөхөх чадваргүй байгаагаас ойрын хугацаанд төлөх боломжгүй байна.

20. Цаашид салбарын үнэ бүрдэлт, түүнийг шийдвэрлэх механизмын асуудлыг бодлогын түвшинд цэгцтэй шийдвэрлэх, үнэ тариф-татаасын асуудлыг цогц байдлаар авч үзэх нөхцлийг бүрдүүлэх, салбарын байгууллагуудын элэгдлийн санг бүрдүүлэх, хянах хэрэгжүүлэх зэрэг асуудлуудыг нэгдмэл байдлаар авч үзэх, зардлын хяналтын системийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

21. Байгууллагуудын нягтлан бодох бүртгэл мэдээллийн системийг сайжруулах талд анхаарч ойрын үед доорх арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын зардлын бүртгэл, түүний хяналтыг оновчтой болгох;
- Мэдээллийн сангийн сургалтыг зохион байгуул, мэдээ, тайлан ирүүлэх ажиллагааг боловсронгуй болгох;
- Санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, мөрдүүлэх зэрэг болно.

Хяналт-үнэлгээнд хамрагдсан ТЗЭ-дийн зарим мэдээллийг хавсаргав.

---oOo---